

Дорноговь аймаг дахь Захиргааны хэргийн  
анхан шатны шүүхэд нэхэмжлэл гаргах нь

20..... оны .... сарын ..... өдөр

Сайншанд

Нэхэмжлэгч: Боржигон овогт Батын Д РД: ХР86254121

Хаяг: Дорноговь аймаг Сайншанд сумын 2-р баг Алтанговийн гудамж ...-.. тоот

Утас: 99562384

Хариуцагч: Дорноговь аймгийн Сайншанд сумын Засаг даргын тамгын газрын дарга

Хаяг : Дорноговь аймаг, Сайншанд сум

Нэхэмжлэлийн шаардлага: Дорноговь аймгийн Сайншанд сумын Засаг даргын тамгын газрын даргын 2015 оны 12 дугаар сарын 12-ны өдрийн "Ажлаас халах тухай" ... дүгээр тушаалыг хүчингүй болгуулах, ажилгүй байсан хугацааны цалинг шүүхийн шийдвэр гарах хүртэлх хугацаагаар гаргуулах

Нэхэмжлэлийн шаардлагын үндэслэл: Миний бие нь Дорноговь аймгийн Сайншанд сумын Засаг даргын тамгын газрын даргын 2014 оны 05 дугаар сарын 10-ны өдрийн ... дугаар тушаалаар тамгын газрын бичиг хэргийн ажилтнаар томилогдон ажилласан. Ажиллах хугацаандаа албан үүрэгтээ хайнга хандаж ямар нэгэн зөрчил дутагдал гаргаж байгаагүй, удирдлагаас өгсөн үүрэг даалгаврыг цаг тухайд нь гүйцэтгэж байсан. Гэтэл Дорноговь аймгийн Сайншанд сумын Засаг даргын тамгын газрын даргын 2015 оны 12 дугаар сарын 12-ны өдрийн "Ажлаас халах тухай" ... дүгээр тушаалаар намайг ажлаас халсан. Уг тушаалд ажлын байранд заагдсан ажил үүргээ цалгардуулсан, ажил тасалсан, ажил үүргээ хангалтгүй биелүүлсэн гэж байгаа нь үндэслэлгүй юм. Миний хувьд дээрх зөрчлийг гаргаагүй, сахилгын арга хэмжээ авагдаж байгаагүй. Нэг удаа эрх бүхий этгээдээс амаар чөлөө авч Улаанбаатар хот хувийн ажлаас явсан болно. Тиймээс энэхүү тушаалыг үндэслэлгүй гэж үзэж байна.

Энэхүү тушаалыг эс зөвшөөрч Төрийн албаны зөвлөлийн Дорноговь аймаг дахь салбар зөвлөлд хандахад Маргаан хянан шалгах комиссын 2015 оны 12 дугаар сарын 30-ны өдрийн дүгнэлтээр намайг ажлаас халсан тушаалыг хууль зүйн үндэслэлтэй байна үзсэн дүгнэлтийг 2016 оны 01 дүгээр сарын 04-ны өдөр хүлээн авч Захиргааны хэргийн шүүхэд хандаж байна.

Хавсаргасан материал:

- Сайншанд сумын ЗДТГазрын даргын 2015 оны ... дүгээр тушаал-1 хуудас
- Сайншанд сумын Засаг даргын тамгын газрын даргын 2014 оны ... дугаар тушаал-1 хуудас
- Ажлын байрны тодорхойлолт-2 хуудас
- Маргаан хянан шалгах комиссын дүгнэлт-1 хуудас
- Нийгмийн даатгалын дэвтрийн хуулбар-2 хуудас

- Улсын тэмдэгтийн хураамж төлсөн баримт-1 хуудас, Данс: Төрийн банк **100060000957**

дансанд **70200** төгрөг тушаана.

Нийт: 8 хуудас /Нэхэмжлэлийг хариуцагчийн тоогоор хувилж өгнө. түүнчлэн итгэмжлэгдсэн төлөөлөгч гаргасан бол итгэмжлэлийг хавсаргана./

Нэхэмжлэл гаргасан:

Б.Д

Та шүүхэд нэхэмжлэлээ бичгээр гаргах бөгөөд нэхэмжлэлд нэхэмжлэгч, эсхүл түүнийг захиргааны хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд төлөөлж байгаа этгээд гарын үсэг зурсан байна.

Нэхэмжлэлд дараах зүйлийг тусгана:

- Нэхэмжлэлийг захиргааны хэргийн ямар шүүхэд гаргаж байгаа
- Нэхэмжлэгч, хариуцагчийн овог, эцгийн болон өөрийн нэр, оршин суугаа хаяг, хуулийн этгээд бол нэр, оршин байгаа газрын хаяг
- Нэхэмжлэлийн шаардлагын үндэслэлд дараах зүйл багтана.

*Захиргааны байгууллага, албан тушаалтны захиргааны хууль бус актын улмаас нэхэмжлэгчийн ямар эрх, хууль ёсны ашиг сонирхол нь хэрхэн зөрчигдсөн*

*Захиргааны хэргийн шүүхээс ямар шийдвэр гаргуулж зөрчигдсөн эрхээ хэрхэн сэргээлгэхийг хүсэж байгаа, түүний үндэслэл Захиргааны хууль бус актын улмаас ямар хохирол учирсан, түүнийг хэрхэн шийдвэрлүүлэх*